

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа, автотээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль тогтоомж

2.1.Автотээврийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх, автотээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, хяналт тавих харилцааг өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй зохицуулахад үйлчилнэ.

3.2. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулах бөгөөд тээвэрлэлтийн тусгай горим шаардсан зохицуулалтыг бусад хуулиар нарийвчлан тогтоосон бол тухайн хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“автотээвэр” гэж автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх болон автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой цогц үйл ажиллагааг;

4.1.2.“автотээврийн хэрэгсэл” гэж авто замаар тээвэрлэлт гүйцэтгэхэд зориулагдсан бүх төрлийн автомашин, чиргүүл, мотоцикл, механизмыг;

4.1.3.“автотээврийн дэд бүтэц” гэж авто зам, замын байгууламж, ачаа, зорчигчийн терминал, зогсоол, талбай, авто замын дагуух үйлчилгээний байгууламжийг;

4.1.4.“автотээврийн хэрэгслийн ашиглалт” гэж тээврийн хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, техникийн бүрэн бүтэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг;

4.1.6.“автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл” гэж автотээврийн хэрэгсэл, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, сэргээн засварлах, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулахтай холбоотой үйл ажиллагааг;

4.1.7.“автомашин үйлдвэрлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт автомашин, иж бүрдэл, эд ангийг угсрах, зохион бүтээж үйлдвэрлэх, эсхүл тус улсын газар нутгаас гадуур байнгын үйлдвэрлэл явуулах хаяг, байршил бүхий тээврийн хэрэгсэлд олгогдох баталгаатай холбоотой бүх талын хариуцлагыг хүлээх, үйлдвэрлэлээс гарч буй бүтээгдэхүүнд баталгаа өгөх үүрэг бүхий хуулийн этгээд, хувь хүнийг;

4.1.8.“автомашин дистрибьютер” буюу “үйлдвэрлэгчийн бүрэн эрхт төлөөлөгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, байнгын хаягтай, Монгол Улсын хууль болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу худалдааны төлөөлөгчийн гэрээ хийсэн, Монгол Улсын автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гадаадын үйлдвэрлэгчийн бүрэн эрхт төлөөлөгч гэдгээ баталгаажуулсан, үйлдвэрлэгчийн тэмдэг, лого ашиглах эрхтэй хуулийн этгээдийг;

4.1.9.“автомашин диллер” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, байнгын хаягтай, Монгол Улсын хууль болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу дистрибьютертэй худалдааны төлөөлөгчийн гэрээ хийсэн, Монгол Улсын автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлөөлөгч гэдгээ баталгаажуулсан, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхээс гадна үйлдвэрлэгчийн тэмдэг, лого ашиглах эрхтэй хуулийн этгээд, хувь хүнийг;

4.1.10.“авто үйлчилгээний байгууллага” гэж автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчид үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;

4.1.11.“автотээврийн салбарын норм, техникийн баримт бичиг” гэж эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан автотээвэр, түүний дэд бүтэц, үйлдвэрлэл, ашиглалттай холбоотой норм, заавар, аргачлал, техникийн баримт бичиг, стандартыг;

4.1.12.“ачаа” гэж автотээврийн хэрэгслээр тээвэрлэхээр хүлээж авсан болон тээвэрлэж байгаа мал, амьтан, эд зүйлсийг;

4.1.13.“аюултай ачаа” гэж тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хохирол учруулж болзошгүй тээвэрлэлт, хадгалалтын тусгай горим шаардсан эд зүйл, хог хаягдлыг;

4.1.14.“ачааны терминал” гэж ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, хадгалах, савлах, ангилах, ачиж буулгахтай холбоотой үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий байгууламжийг;

4.1.15.“автомат удирдлагатай автотээврийн хэрэгсэл” гэж автомат удирдлагатай системээр тоноглогдсон, хүний оролцоогүйгээр тээвэрлэлт гүйцэтгэх зориулалт бүхий автомашин;

4.1.16.“автотээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ” гэж тухайн автотээврийн хэрэгслийн талаарх мэдээлэлийг агуулсан нууцлал бүхий чиптэй бичиг баримтыг;

4.1.17.“дамжин өнгөрөх тээвэр” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх тээвэрлэлтийг;

4.1.18.“жолооч” гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.3-д заасан хүнийг;

4.1.19.“жуулчин тээвэр” гэж аялал жуулчлалын байгууллагаас жуулчдад үзүүлж байгаа зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг;

4.1.20.“зорчигч” гэж нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчих тасалбар, түүнтэй адилтгах баримт бичигтэй хүнийг;

4.1.21.“зорчигчийн терминал” гэж зорчигч хүлээн авах, үдэн гаргах, амрах болон зорчигчийн ачаа, тээшийг хүлээн авах, хүлээлгэн өгөхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий байгууламжийг;

4.1.22.“мөсөн замын тээвэр” гэж гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед тогтоосон хугацаа, замналын дагуу мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийг;

4.1.23.“мэргэшсэн жолооч” гэж эрх бүхий байгууллагаас мэргэшлийн үнэмлэх авсан жолоочийг;

4.1.25. “нийтийн зорчигч тээвэр” гэж нийтийн хэрэгцээний тээврийн хэрэгслээр хийгдэж буй зорчигчийн тогтмол болон тогтмол бус тээвэрлэлтийг;

4.1.26.“зорчигчийн тогтмол тээвэр” гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон чиглэл, замнал, цагийн хуваарийн дагуу зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа зорчигч тээвэрлэлтийг;

4.1.27.“Зорчигчийн тогтмол бус тээвэр” гэж зорчигчийн тогтмол тээврээс бусад зохион байгуулалттай хийгдэж буй зорчигч тээвэрлэлтийг;

4.1.28.“олон улсын тээвэр” гэж хоёр буюу түүнээс дээш улсын хилийг нэвтрэн хийгдэж байгаа тээвэрлэлтийг;

4.1.29.“орон нутгийн тээвэр” гэж нийслэл, аймаг, сумын нутаг дэвсгэрт хийгдэх тээвэрлэлтийг;

4.1.30.“ослыг шинжлэн шалгах” гэж тээвэрлэлтэд гарч болзошгүй осол, зөрчил, техникийн саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан ослын шалтгааныг тогтоох, аюулгүй байдлын зөвлөмж боловсруулах үйл ажиллагааг;

4.1.31.“техникийн хяналтын үзлэг” гэж автотээврийн хэрэгсэлд тавигдах стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг хийх, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг;

4.1.32.“тусгай замын тээвэр” гэж Авто замын тухай хуулийн 4.1.26-д заасан тусгай зориулалтын авто замаар гүйцэтгэх тээвэрлэлтийг;

4.1.33.“тээвэрлэлт” гэж автотээврийн хэрэгслээр ачаа болон зорчигчийг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөхтэй холбоотой ажил, үйлчилгээг;

4.1.34. “тээвэрлүүлэгч” гэж ачаа илгээгч, хүлээн авагч болон тээвэр зуучийг;

4.1.35.“тээвэрлэгч” гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

4.1.36 “хот хоорондын тээвэр” гэж аймаг хооронд эсхүл аймаг нийслэл хооронд хийгдэх тээвэрлэлтийг;

4.1.37.“чиглэл” гэж тээвэрлэлтийн эхлэл төгсгөлийг тогтоосон байршлыг;

4.1.38.“замнал” гэж тээвэрлэлтийн эхлэлээс төгсгөлийн байршил хүртэлх замын зураглалыг;

4.1.39.“хяналтын төхөөрөмж” гэж олон улсын хэлэлцээрт заасан тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон жолоочийн ажлын тодорхой хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг автоматаар, эсхүл хагас автоматаар бүртгэж, харуулах, тээврийн хэрэгсэлд суурилуулах зориулалттай төхөөрөмжийг.

5 дугаар зүйл.Автотээврийн салбарын үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1.Автотээврийн салбарын үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

5.1.1.автотээврийн үйл ажиллагаа нь нэгдмэл, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдсан байх;

5.1.2.автотээврийн үйлчилгээ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлтэд нийцсэн байх;

5.1.3.үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АВТОТЭЭВРИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.1.1. автотээврийн оновчтой дэд бүтэц, тээврийн үр ашигтай нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, тээвэрлэлтийн сүлжээний зураглалыг батлах;

6.1.2. автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалтыг нь харгалзан техникийн хяналтын үзлэгт орох хугацаа, төлбөрийн хэмжээг тогтоох;

6.1.3. авто зам дагуух үйлчилгээний байгууламжийн зориулалтаар ашиглах газрын талаар шийдвэр гаргах;

6.1.4. Үндэсний тээврийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

6.1.5. автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

6.1.6. хууль тогтоомжид заасан бусад эрх.

7 дугаар зүйл. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. автотээврийн талаар хөгжлийн бодлогын баримт бичиг, баримталж буй бодлогын талаар санал гаргах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

7.1.2. автотээврийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, биелэлтийг хангуулах, хяналт шалгалт хийх ;

7.1.3. автотээврийн хэрэгслийн бүртгэл, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

7.1.4. автотээврийн салбарын хөрөнгө оруулалтыг нийгэм-эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн төлөвлөх;

7.1.5. олон улсын тээврийг хөгжүүлэх зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

7.1.6. Автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах;

7.1.7. Орон нутгийн тээврийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах;

7.1.8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.1-д заасан тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан болон энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан автотээврийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх;

7.1.9. хуульд заасан зөвшөөрөл олгох, зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих;

7.1.10. Монгол Улсын нэгдэн орсон автотээврийн салбарын олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах;

8 дугаар зүйл. Автотээврийн асуудал хариуцсан төрийн өмчийн байгууллагын чиг үүрэг

8.1. Автотээврийн асуудал хариуцсан төрийн өмчийн хуулийн байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. автотээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2. автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.3. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг зохион байгуулах

8.1.4. олон улсын болон дотоодын ачаа тээвэрлэлт эрхлэгч этгээдийг бүртгэх

8.1.5. олон улс, хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих

8.1.6. автотээврийн хэрэгслийн хог хаягдлын санг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.7. автотээврийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх;

8.1.8. автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх

8.1.9. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх автомашинд зөвшөөрлийн бичиг олгох, зөвшөөрлийн бичгийн ашиглалтад хяналт тавих

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

9.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. автотээврийн талаарх хөгжлийн бодлогын баримт бичиг, автотээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

9.1.2. орон нутгийн тээврийн үйлчилгээг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

9.1.3. хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч тээврийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд тээвэрлэгчид зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр гэрээ байгуулж, нийтийн зорчигч тээврийг гүйцэтгүүлж болно;

9.1.4. нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрт нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зурган хэлбэрээр байрлуулах, өөрчлөх арга хэмжээг зохион байгуулах;

9.1.5. тухайн нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуурын ус хөлдсөн үед орон нутгийн цаг уур, орчны шинжилгээний байгууллага, авто замын байгууллагатай хамтран мөсний даацыг тодорхойлж, мөсөн дээгүүр хийх тээвэрлэлтийн эхлэх, дуусах хугацаа, чиглэл, замналыг тогтоон тэмдэгжүүлж, тээвэрлэгчдийг мэдээллээр хангах, хяналт тавих;

9.1.6. цаг үеийн шуурхай тээвэрлэлтийг улсын захиалга, даалгаврын дагуу нутаг дэвсгэртээ шуурхай зохион байгуулах;

9.1.7. байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, автотээврийн дэд бүтцийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад өөрийн эрх мэдлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

9.1.8. харъяалах нутаг дэвсгэртээ автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх;

9.1.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9.2. орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

10 дугаар зүйл.Автотээврийн дүрэм, журам, норм норматив

10.1.Автотээврийн салбарт доор дурдсан дүрэм, журам, норм, жишиг тарифыг баталж мөрдүүлнэ:

10.1.1.ачаа тээвэрлэх дүрэм;

10.1.2. автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журам;

10.1.3. автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах, шалгалт авах, үнэмлэх олгох журам;

10.1.4. автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам, гэрчилгээний загвар батлах;

10.1.5. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам;

10.1.6. жолоочийн хөдөлмөр, амралтыг зохицуулах, хөдөлмөр, амралтын горимын хяналтын төхөөрөмж ашиглах, хянах журмыг батлах.

10.1.7. зорчигч тээвэрлэх дүрэм;

10.1.8. нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим систем ашиглах журам;

10.1.9. автотээврийн хэрэгслийн ашиглалтын жишиг норм;

10.1.10. тээвэрлэлтийн жишиг тариф;

10.1.11. авто үйлчилгээний байгууллагад зэрэглэл тогтоох журам;

10.1.12. автотээврийн хэрэгслийн хог хаягдлын санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам

10.1.13. ачаа, зорчигчийн терминалын үйл ажиллагааны дүрэм;

10.1.14. хяналтын төхөөрөмж суурилуулах шаардлагатай тээврийн хэрэгслийн ангилал, төрөл, тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд суурилуулах хяналтын төхөөрөмжид тавигдах шаардлага, хяналтын төхөөрөмжийг ашиглах, үйлчилгээ хийх, үйл ажиллагааг хянах журам;

10.1.15. тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмжийг суурилуулах, шалгах, засвар, үйлчилгээ хийх журам;

10.1.16. тээврийн хэрэгсэлд суурилуулсан хяналтын төхөөрөмжид карт олгох, уг картад тавигдах шаардлага, картыг бүртгэх, хяналт тавих журам;

10.1.17. тээврийн хэрэгсэлд суурилуулсан хяналтын төхөөрөмжийн ажиллагаа, гэрчилгээжүүлэлт болон хяналтын төхөөрөмжийн картын мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хяналтын төхөөрөмжийн хяналт, зохицуулалтын систем ашиглах журам”.

10.1.18. аюултай ачаа тээвэрлэх журам

10.2. Энэ хуулийн 10.1.1, 10.1.4, 10.1.5, 10.1.7, 10.1.9-10.1.18-д заасан журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, 10.1.2, 10.1.3, 10.1.6-д заасан журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран, 10.1.8-д заасан журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол банкны Ерөнхийлөгчтэй хамтран тус тус батална.

11 дүгээр зүйл. Автотээврийн хог хаягдлын сан

11.1. Автотээврийн хог хаягдлын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

11.1.1. автотээврийн хэрэгсэл, сэлбэг, эд анги, тос тосолгооны материалын импортын гаалийн албан татварын 5 хувь;

11.1.2. олон улсын тээврийн зөвшөөрлийн бичгийн орлогын 5 хувь;

11.1.3. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн 10 хувь;

11.1.4. автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар олсон орлогын 50 хувь;

11.1.5. Тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн орлогын 20 хувь.

11.2. автотээврийн хог хаягдлын сангийн эх үүсвэрийг автотээврийн салбарт үүсч буй хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа болон эко тээвэрлэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд зарцуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТЭЭВЭРЛЭЛТ

12 дугаар зүйл. Тээвэрлэлтийн зохицуулалт

12.1. олон улсын тээврийн чиглэл, замналыг тогтоох, өөрчлөх асуудлыг автотээврийн харилцааны тухай олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зохицуулна.

12.2. аймаг, нийслэл хоорондын тээврийн чиглэл, замналыг тогтоох, өөрчлөх, зорчигч тээврийн үйлчилгээний давтамж, тээвэрлэгчийг томилох шийдвэрийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

12.3. аймаг хоорондын тээврийн чиглэл, замналыг тогтоох, өөрчлөх, зорчигч тээврийн үйлчилгээний давтамж, тээвэрлэгчийг томилох шийдвэрийг тухайн аймгуудын Засаг дарга нар хамтран гаргана.

12.4. орон нутгийн тээврийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

12.5.Энэ хуулийн 12.3, 12.4-т заасан ачаа, зорчигчийн тээврийн чиглэлийг тогтооход олон улс болон улсын чанартай хатуу хучилттай авто замтай давхцсан тохиолдолд автотээврийн асуудал эрхэслэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

12.5.Тээвэрлэлтийн үйлчилгээнд хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон автотээврийн хэрэгсэл ашиглана.

13 дугаар зүйл.Тээвэрлэгчийн эрх, үүрэг

13.1.Тээвэрлэгч нь дараах эрх эдэлнэ:

13.1.1.авто замын байгууллагаас авто зам, гүүрийг автотээврийн хэрэгсэл зорчиход саадгүй байлгахыг шаардах, авто зам, гүүрийн ашиглалтын нөхцөл хангаагүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

13.1.2.зорчих тасалбар аваагүй зорчигч болон тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бэлтгээгүй ачааг тээвэрлэхээс татгалзах;

13.1.3.тээвэрлэлтийн гэрээгээр хүлээсэн үүрэг, тээвэрлэлтийн хөлсийг тээвэрлүүлэгчээс шаардах;

13.1.4.тээвэрлэгч нь нийгмийн хэв журам сахих, үйлчилгээний дүрэм, журмыг биелүүлэх шаардлагыг зорчигчид тавих.

13.2.Тээвэрлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

13.2.1.тээвэрлэлтийг тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх;

13.2.2.авто зам, замын байгууламж болон автотээврийн дэд бүтцийг техникийн нөхцөл, шаардлагын дагуу ашиглах;

13.2.3.өөрийн өмчлөлийн автотээврийн хэрэгслээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх;

13.2.4.тээвэрлүүлэгчийг тээвэрлэлттэй холбоотой үнэн зөв мэдээллээр хангах.

13.2.5.Олон улсын болон хот хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэхдээ холбогдох байгууллагад бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл.Тээвэрлүүлэгч, зорчигчийн эрх, үүрэг

14.1.Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараах эрх эдэлнэ:

14.1.1.тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус автотээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

14.1.2.нийтийн тээврийн тогтоосон замнал, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;

14.1.3.тээвэрлэлтийн үнэ тариф, замнал, үйлчилгээний цагийн хуваарь, ачаа хүргэх хугацааны талаар үнэн зөв мэдээлэл авах;

14.1.4. тээвэрлэлтийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд олон улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигч хүндэтгэх шалтгаанаар худалдан авсан тасалбарт заасан чиглэлд зорчих боломжгүй болсон тохиолдолд зохих шимтгэлийг төлсний үндсэн дээр тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцаан авах;

14.2.Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараах үүрэг хүлээнэ:

14.2.1.ачааны савлалт, баглаа боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх;

14.2.2.ачих, буулгах машин механизм, нэмэгдэл төхөөрөмж, хүн хүчийг бэлэн байлгаж ачааг тогтоосон хугацаанд ачих, буулгах, өөрийн хаягтай буюу гэрээт ачааг хүлээн авах;

14.2.3.ачааг тээвэрлэх, хадгалах нөхцөл, горимын тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

14.2.4.ачааг ачсан, хүлээн авсан тухай тээвэрлэлтийн баримт бичигт тэмдэглэж баталгаажуулан тээвэрлэгчид олгох;

14.2.5.нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигч нь зорчих тасалбарыг /төлбөрийн цахим карт/ худалдан авах;

14.2.6.нийтийн зорчигч тээврээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;

14.2.7.нийтийн зорчигч тээврээр зорчихдоо автотээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй байх;

14.2.8.зорчигч нь улс, хот хооронд, орон нутагт зорчихдоо иргэний үнэмлэх, холбогдох бусад бичиг баримт, тэдгээрийг шалгах эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзүүлэх.

14.2.9.ачааг стандартад заасан даац, оврын хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, зайлшгүй тохиолдолд тээвэрлэгчтэй хамтран холбогдох байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах.

15 дугаар зүйл.Зорчигч тээвэрлэлт

15.1.Зорчигч тээвэрлэлтийг энэ хуулийн 10.1.8-д заасан зорчигч тээвэрлэх дүрмээр зохицуулна. Дүрэмд дараах зохицуулалтыг заавал тусгана:

15.1.1. Зорчигч тээврийн үйлчилгээг стандартад нийцсэн автотээврийн хэрэгслээр гүйцэтгүүлэх;

15.1.2.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгүүлэх, зорчигчийн ая тухтай, аюулгүй зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нөхцөл шаардлагыг тусгах;

15.1.3. Олон улсын зорчигч тээврийн үйлчилгээг 2 жилээс доошгүй хугацаанд дотоодод нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн туршлагатай шаардлага хангасан тээвэрлэгч гүйцэтгэх;

16 дугаар зүйл.Ачаа тээвэрлэлт

16.1. Ачаа тээвэрлэлтийг энэ хуулийн 10.1.1-д заасан ачаа тээвэрлэх дүрмээр зохицуулна. Дүрэмд дараах зохицуулалтыг заавал тусгана:

16.1.1. Нэгдсэн зохион байгуулалттайгаар хийгдэх тээвэрлэлтийг захиалагч байгууллага нь шаардагдах автотээврийн хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэн тэдгээрийг оролцуулах зарчмыг баримтлах;

16.1.2. Аюултай ачаа, овор ихтэй, урт, хүнд ачаа, хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг холбогдох хууль, хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт заасан нөхцөл, шаардлагын дагуу тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх;

16.3. Ачаа тээврийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, харилцан мэдээллээ солилцох нөхцөлийг бүрдүүлэх, ачааны дагалдах бичиг, замын хуудас зэрэг тээвэрлэлтийн баримт бичгүүдийг цахим сүлжээнд байршуулах, хэрэглэгчид ашиглах боломжоор хангах;

17 дугаар зүйл. Аюултай ачааны тээвэрлэлт

17.1. Авто тээврээр аюултай ачааг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, тээвэрлэх, буулгах, шилжүүлэх, хадгалах үйл ажиллагааг энэ хуулийн 10.1.18-д заасан журмаар зохицуулна.

17.2. Аюултай ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг зориулалтын тоног төхөөрөмж бүхий зам, талбайд стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

17.3. Зорчигч тээвэрлэлтийн явцад аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.

17.4. Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг Монгол Улсын олон улсын боомтоор гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл. Тээвэр зууч

18.1. Байнгын ачаа тээвэрлэлтийг зуучаар дамжуулан гүйцэтгүүлж болно.

18.2. Зууч нь байнгын ачаа тээвэрлэлт эрхлэгчийг тээвэрлүүлэгчтэй холбон зуучлах, үйл ажиллагааг нь уялдуулах, тээвэрлэлтийн баримт бичгийг бүрдүүлэх, тээвэрлэлтийн явц, аюулгүй байдалд хяналт тавих, тээвэрлэлтэд учрах эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

18.3. Тээвэр зуучийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна.

18.3.1. олон улсын тээвэр зууч

18.3.2. дотоодын тээвэр зууч

18.4. Тээвэр зуучийн эрх, үүрэг:

18.4.1. үйлчлүүлэгчтэй тээвэр зуучийн гэрээг байгуулж, хэрэгжүүлэх.

18.4.2. тээвэрлэлтийн даатгалтай холбоотой баримт бичиг бүрдүүлэх;

18.4.3. гааль, хорио цээр, эрүүл ахуйн болон бусад хяналт шалгалттай холбоотой баримт бичиг бүрдүүлэх;

18.4.4. үйлчлүүлэгчид тээвэрлэлтийн явц, ачааны байршлын талаар мэдээлэл өгөх;

18.4.5. агуулахын үйлчилгээ үзүүлэх;

18.4.6.бусад нэмэлт үйлчилгээ.

18.5.Тээвэр зууч нь үйлчлүүлэгчээс ачааг хүлээн авснаас, ачааг хүлээлгэн өгөх хүртэл ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцна.

18.6.Тээвэр зуучийн үйлчилгээний ангилал, зэрэглэл, үйл ажиллагаа, хариуцлагын хязгаар, үйлчилгээнд тавигдах шаардлагыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АВТОТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

19 дүгээр зүйл. Автотээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

19.1.Автотээврийн аюулгүй байдал гэдэгт автотээврийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хамааруулж ойлгоно.

19.2.Автотээврийн аюулгүй ажиллагаа нь техник, технологи болон үйл ажиллагааны талаарх холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

18.3.Тээвэрлэлтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг тээвэрлэлтэд оролцогч талууд хариуцах бөгөөд аюулгүй байдлыг хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

18.4.Автотээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг тээврийн төрөл тус бүрээр тогтооно.

20 дугаар зүйл.Автотээврийн дэд бүтцийн бүрэлдэхүүн

20.1.Автотээврийн дэд бүтэц нь тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээ, төлөвлөлттэй уялдсан, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангасан, тав тухтай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх бөгөөд үйлчлэх хүрээнээсээ хамааран олон улсын, бүс нутгийн, орон нутгийн гэсэн төрөлтэй, олон улсын болон үндэсний тээврийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

20.2.Автотээврийн дэд бүтцийн үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлага, зэрэглэлийг стандартаар тогтооно.”

21 дүгээр зүйл. Автотээврийн хэрэгсэлд тавих шаардлага

21.1. Тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлын шаардлага, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, экологи, хөдөлмөр хамгаалалын талаарх хууль тогтоомжоор тавигдах шаардлага, техникийн нөхцөл, стандартын шаардлагыг хангасан байвал зохино.

21.2. Энэ хуулийн 21.1-д заасан шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэл оруулж ирэх, борлуулах, ашиглахыг хуулиар хориглоно.

22 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааг хангах, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлийн түвшинг бууруулах

22.1.Тээвэрлэгч нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хүрээлэн буй орчноо хамгаалах үүрэгтэй.

22.2. Аюултай ачаа тээвэрлэх хугацаанд түүнийг хамгаалах, дагалдах үүргийг илгээгч эсвэл хүлээн авагч талуудын аль нэг нь хүлээнэ.

22.3. Аюултай ачааг тээвэрлүүлэхдээ илгээгч, хүлээн авагч нь тэдгээр ачаа тээшийн тээвэрлэлтийн аюулгүй байдалд баталгаа өгөх, гарч болзошгүй сүйрэл ослоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бие бүрэлдхүүн зэрэг шаардлагатай арга хэмжээг авахаас гадна сүйрэл осол гарсан тохиолдолд түүнээс гарсан үр дагаварыг арилгах, цэвэрлэх, устгах ажлыг хамтран гүйцэтгэнэ.

22.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрших, хуваарилагдах эсвэл дамжин өнгөрөх гадаад улс орны тээвэр, тээврийн хэрэгсэлүүд Монгол Улсын хууль тогтоомжид заасан хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй байх шаардлагыг ханган дагаж мөрдөх үүрэгтэй.

23 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл

23.1. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, түүний эд анги нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй байна.

23.2. Автомашин үйлдвэрлэгч нь аливаа тохиромжгүй орчин (үерийн аюул, ус, намаг, цэвдэг, сул шороо, хог хаях цэг бусад бохирдол)-оос тусгаарлагдсан, суурьшмал бүсийн гадна, үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаагаа явуулна.

23.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын стандарт (MNS), Олон Улсын стандарт (ISO), Нэгдсэн Үндэстний байгууллагын Европын Эдийн Засгийн Дотоодын тээврийн хорооны техникийн зохицуулалт (UNECE WP.29)-тай уялдсан байна.

23.4. Үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан, худалдааны үйл ажиллагааг албан ёсоор эрхлэх зөвшөөрөл бүхий автомашины дистрибьютер, диллэрээр дамжуулан худалдаанд нийлүүлнэ.

24 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн ослыг шинжлэн шалгах

24.1. Тээвэрлэлтийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болзошгүй ослоос сэргийлэх, бодлогын болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үйл ажиллагаанд ашиглах зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг хийнэ.

24.2. Шинжлэн шалгах ажиллагааны дүгнэлт, зөвлөмжийг иргэн, хуулийн этгээдийг гэм буруутайд тооцох, хариуцлага хүлээлгэхэд ашиглахгүй.

24.3. Шинжлэн шалгах ажиллагааг хараат бус, бие даасан, хууль дээдлэх зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

24.4. Ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага, түүний шинжлэн шалгагчаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлбэл зохино.

24.5. Шинжлэн шалгагчийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу томилон ажиллуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ

25 дугаар зүйл.Авто үйлчилгээ эрхлэгч

25.1.Авто үйлчилгээнд автотээврийн хэрэгслийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангахтай холбоотой дараах үйл ажиллагаа хамаарна:

25.1.1.автотээврийн хэрэгсэл, түүний сэлбэг хэрэгсэл, тос, тосолгооны материалын импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаа;

25.1.2.автотээврийн хэрэгслийн техникийн засвар, үйлчилгээ;

25.1.3.автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой бусад үйлчилгээ.

25.2.Авто үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

25.3.Авто үйлчилгээ эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

25.3.1.үйл ажиллагаанд тавигдаж буй стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд тохирлын үнэлгээ хийлгэж, баталгаажуулах;

25.3.2.стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг засвар, үйлчилгээнд ашиглах;

25.3.3.хэрэглэгчдэд худалдах сэлбэг хэрэгсэл, тос, тосолгооны материал нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг хангасан, хүлээн зөвшөөрөгдсөн гарал үүслийн гэрчилгээтэй байх;

25.4.Стандартын шаардлага хангаагүй, хүлээн зөвшөөрөгдсөн гарал үүслийн гэрчилгээгүй сэлбэг хэрэгсэл, тос, тосолгооны материал худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

26 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл

26.1.Автотээврийн хэрэгсэл өмчлөх, эзэмших эрх үүсэх, дуусгавар болох, техникийн өөрчлөлтийг бүртгэхтэй холбоотой хуульд заасан үйл ажиллагааг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл гэнэ.

26.2.Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл нь дараах төрөлтэй байна:

26.2.1.автотээврийн хэрэгсэлийг шинээр бүртгэж, бүртгэлийн дугаар олгох;

26.2.2.автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг бүртгэх;

26.2.3.автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах;

26.2.4.автотээврийн хэрэгслийн ашиглалтын бүртгэл.

26.3.Монгол Улсад бүртгэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага автотээврийн хэрэгсэл өмчилснөөс хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш 1 сарын дотор бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

26.4.Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлуулж болно.

26.5.Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулна.

26.6.Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагад ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг тухайн асуудал эрхэлсэн цэргийн автотехникийн хяналтын алба зохион байгуулна.

26.7.Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэгч бүртгэж, бүртгэлийн дугаар, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

26.8.Дараах автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэхийг хориглоно:

26.8.1.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа стандартын шаардлага хангаагүй;

26.8.2.хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэгт “сэлбэг”, “бүхээг” гэж бичигдсэн тохиолдолд;

26.8.3.зохих хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэлт хийгээгүй, албан татвар төлөөгүй;

26.8.4.тухайн автотээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлт нь техникийн баримт бичгээс зөрсөн, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн.

26.9.Улсын бүртгэгч нь автотээврийн чиглэлээр дээд боловсролтой, эсхүл эрх зүйч мэргэжилтэй, улсын бүртгэгч бэлтгэх сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн байна.

26.10.Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь улсын хэмжээнд нэгдмэл байна.

26.11.Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг, тэмдгийн үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

27 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт

27.1.Автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналтын үзлэг хийнэ.

27.2.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг энэ хуулийн 31.1.2-д заасан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

27.3.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх байгууллага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу итгэмжлэгдсэн байна.

27.4.Үйлдвэрлэгдсэнээс хойш эхний 2 жилд автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй байж болох бөгөөд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг 6 сар тутамд, бусад автотээврийн хэрэгслийг 12 сард нэг удаа техникийн хяналтын гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулна.

27.5.Техникийн хяналтын гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг /байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

27.6.Дараах тохиолдолд энэ хуулийн 26.4-т заасан хугацааг үл харгалзан автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна:

27.6.1.хөдөлгүүр болон арлыг сольсон, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан, ажил, үйлчилгээний шаардлагын дагуу үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр автотээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн;

27.6.2.өмчлөгч, эзэмшигч нь хүсэлт гаргасан;

27.6.3.осолд өртөж агрегат, зангилаа, механизмд эвдрэл гарсныг засварласан.

27.7.Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж, стандартын шаардлагыг хангасан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэнэ.

27.8.Гамшиг, осол, аюулт үзэгдэлд өртсөн автотээврийн хэрэгслийг цаашид ашиглаж болох эсэхэд эрх бүхий мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргана.

27.9. Тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын нэгдсэн системтэй байна. Энэхүү систем нь Монгол Улсын хэмжээнд нэгдмэл байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

28 дугаар зүйл. Автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох

28.1. Автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сунгах, хүчингүй болгох асуудлыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл хариуцна.

28.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилно.

28.3. Автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг энэхүү хуулийн 10.1.2-т заасан журмаар зохицуулна.

28.4. Автотээврийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг автотээврийн салбарын хүний нөөц, сургалтын мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан зохион байгуулна.

29 дүгээр зүйл.Мэргэшсэн жолооч

29.1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, тусгай горим шаардсан ачааны тээвэрлэлт болон бусад мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан ажил үйлчилгээг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлнэ.

29.2. Мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.3.Мэргэшсэн жолоочийн үнэмлэх нь тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхийн хамт хүчинтэй.

29.4.Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах, шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг энэхүү хуулийн 10.1.3-т заасан журмаар зохицуулна.

29.5.Мэргэшсэн жолоочийн эрх дор дурдсан тохиолдолд дуусгавар болно:

29.4.1.мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан;

29.4.2.автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр хүчингүй болсон;

29.6.Мэргэшсэн жолоочийн эрх дуусгавар болсон нь тухайн ангиллын автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хүчингүй болгох, хасах үндэслэл болохгүй;

29.6.Энэ хуулийн 29.5-т заасан шалтгаан арилсан нөхцөлд мэргэшсэн жолоочийн эрхийг сэргээнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ АВТОТЭЭВРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

30 дугаар зүйл.Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан

30.1.Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:

30.1.1.автотээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан;

30.1.2.мэргэшсэн жолоочийн мэдээллийн сан;

30.1.3.ачаа тээврийн мэдээллийн сан;

30.1.4.зорчигч тээврийн мэдээллийн сан;

30.1.5.автотээврийн хяналтын мэдээллийн сан;

30.1.6.салбарын хүний нөөц, сургалтын мэдээллийн сан

30.1.7.жолоочийн даатгалын сан

30.2.Автотээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээний мэдээллийг хамруулна.

30.3.Мэргэшсэн жолоочийн мэдээллийн санд мэргэшсэн жолооч бэлтгэх сургалт эрхлэх байгууллага, мэргэшсэн жолооч нарын нэгдсэн бүртгэл, тэдгээрт эрх олгосон ангилал, эрхийн хүчинтэй хугацаатай холбогдсон мэдээллийг хамруулна.

30.4.Ачаа тээврийн мэдээллийн санд тээвэрлэгчийн мэдээлэл, тээсэн ачааны тоо хэмжээ, давтамж, хамрах хүрээ, төрөл, ангилал болон автотээврийн терминалын үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг хамруулна.

30.5.Зорчигч тээврийн мэдээллийн санд жуулчин тээвэр болон нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, үнэ тариф, чиглэл, автотээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг тодорхойлох, зохицуулах, цаг агаар, байгалийн гамшигтай холбоотой мэдээлэл, зорчигч тээвэртэй холбогдсон статистик мэдээллийг хамруулна.

30.6.Автотээврийн хяналтын мэдээллийн санд автотээврийн үйл ажиллагаанд гарсан зөрчил, тэдгээрт хийсэн эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд тавих хяналт шалгалттай холбогдсон мэдээллийг хамруулна.

30.7. Салбарын хүний нөөцийн мэдээллийн санд автотээврийн салбарын хүний нөөц болон сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хамруулна.

30.7.Автотээврийн мэдээллийн нэгдсэн сан нь хилийн хяналтын байгууллагууд, даатгал, татвар, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон бусад холбогдох байгууллагын мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцох боломжтой байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

31 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл

31.1.Доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ:

31.1.1.нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх;

31.1.2.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

31.1.3.аюултай ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх

31.2.Энэ хуулийн 31.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан байгууллага, албан тушаалтан олгож үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

31.3.Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах нөхцөл, шаардлагыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТ

32 дугаар зүйл.Автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх

32.1. Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

32.2. Автотээврийн салбарт захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч нь автотээврийн үйлчилгээнд мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах үүрэгтэй ажиллана.

32.4. Автотээврийн хяналт, шалгалтын мэргэжлийн төв, орон нутгийн хяналтын байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу олгоно.

32.5.Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагчийн эрхийг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

33 дугаар зүйл.Автотээврийн хяналтын улсын байцаагч

33.1.Автотээврийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, 10.12-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ автотээврийн хэрэгслийг түр зогсоож шалгах, шаардлагатай гэж үзвэл тухайн автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, тээвэрлэлтийн баримт бичгийг гаргасан зөрчлийг арилгаж дуустал түр хураах;

33.1.2.мэргэшсэн жолоочийн эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;

33.1.3.автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авах;

33.1.4.автотээврийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

33.2.Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

33.3.Автотээврийн хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг, техник хэрэгсэл хэрэглэх бөгөөд дүрэмт хувцасны загварыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

33.4 Олон улсын хилийн боомтод автотээврийн үйл ажиллагаанд хяналт тавих автотээврийн хяналтын улсын байцаагч ажиллана.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

34 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

34.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

34.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

35 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

35.1.Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг